

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр, Даваа гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-16</i>
1. Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан	3-16

***Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Ёс зүй, дэгийн байнгын хорооны 05 дугаар сарын 05-ны өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 17 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Б.Жавхлан, Д.Жаргалсайхан, Ч.Лодойсамбуу.

Нэг.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, мөн газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга Д.Үүрийнтуяа, мөн газрын Хууль тогтоомж, тогтоол шийдвэр хариуцсан референт Ш.Бумаажав, ахлах шинжээч Б.Отгонцэцэг, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, мөн зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, мөн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатар, Захиргаа, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Энхээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас, Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа, зөвлөх Б.Отгонсүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн тавьсан асуултад Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, А.Ариунзаяа, Д.Рэгдэл нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг сонсов.

Уг асуудлыг 14 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 46 минут үргэлжилж, ирвэл зохих 12 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр, Даваа гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим, 13 цаг 17 минут

ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баярбаатар: Ирц хүрсэн байна. 2025 оны намрын ээлжит чуулганы 5 дугаар сарын 5-ны өдрийн Ёс зүй, дэгийн Байнгын хорооны хурлын ирцийг танилцуулъя. Баярмагнай овогтой Баярбаатар ирсэн байна. Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн ирсэн байна. Жамбын Батсуурь гишүүн ирсэн байна. Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна. Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна. Доржзовдын Энхтуяа гишүүн ирсэн байна. Ирц хүрсэн учраас 5 дугаар сарын 5-ны өдрийн хурлыг нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудлыг танилцуулна. Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэх гэсэн 1 асуудал байгаа. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу. Байхгүй бол хэлэлцэх асуудалдаа орно.

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын Тамгын газраас ирүүлсэн Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланд хийсэн дүн шинжилгээг гишүүдэд тараасан байгаа.

Монгол Улсын Засгийн газраас ирүүлсэн Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын хууль, тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгийн танилцуулгыг мөн та бүхэнд шуудангаар тараасан байгаа.

Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16.3-д Байнгын хороо Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг 16.2-т заасан танилцуулгыг хүлээн авснаас хойш 1 сарын дотор хэлэлцэнэ гэж заасан байдаг. Энэ хуулийн хугацаа миний ойлгосноор 7-ны өдөр дуусаж байгаа гэж ойлгож байгаа. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат орж ирээгүй байна уу. Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албаны үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа, Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын зөвлөх Б.Отгонсүрэн, Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ мониторингийн газрын судлаач-ажилтан Г.Анужин, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ мониторингийн газрын дарга Үүрийнтуяа. Байна уу. Засгийн гарын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын Хууль тогтоомж, тогтоол

шийдвэр хариуцсан референт Ш.Бумаажав, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын Хууль тогтоомж, тогтоол шийдвэр хариуцсан ахлах шинжээч Б.Отгонцэцэг, Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатар, Ёс зүйн хорооны Захиргаа, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Энхээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115.6-д энэ хуулийн 115.2-т заасан Засгийн газрын тайлан илтгэлийг Ерөнхий сайд, холбогдох байгууллагын тайлан, илтгэл, мэдээллийг тухайн байгууллагын дарга, Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж байгаа тайлан, илтгэл, мэдээлэл, байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж болно гэсэн заалттай байгаа. Танилцуулгыг хэн хийх юм. Гантөмөр сайд орж ирж байгаа юу. Энэ Одбаяр сайд хааччихсан юм.

Төрийн байгуулалтын байнгын хорооны өнгөрсөн хуралдаан дээр энэ асуудал хойшилсон юм байна лээ. Шалтгаан нь юу байсан юм. Энэ салбарын сайд нар ер нь хариуцсан ажилдаа жоохон хариуцлагатай хандаж баймаар байна. Энэ нэг Улсын Их Хурлын гишүүд гээд хэдэн мануухай Байнгын хорооны хурлаа зохион байгуулаад л баахан юм яриад л, тогтоол гаргаад л хүргүүлдэг. Эргээд хэрэгжиж байгаа зүйл заалт нэгээхэн ч байдаггүй. Ингэх байсан юм бол бид нар энд хуралдаж, шийдвэр гаргах зайлшгүй тийм шаардлага ер нь байгаа юу. Хэрэгждэггүй баахан тогтоолтой. Их Хурлын тогтоол нь ч тэр, Байнгын хорооны тогтоол нь ч тэр.

Би 1 жишээ дурдахад тэр Улсын Их Хурлын 2024 оны 31 дүгээр тогтоол. 8 заалттай тогтоол өнөөдөр 1 нь ч хэрэгжээгүй. Уг нь орон тоо нэмэгдээд л ажил алба нь нэмэгдээд л байх шиг, хүний тоо нь нэмэгдээд л байх шиг байх юм. Эсвэл ажлаа бардаггүй юм уу та нар. Эсвэл энэ тогтоол хэрэгжүүлье гэсэн сэтгэл байдаггүй юм уу. Цааш цаашдаа Өнөрбаяр дарга аа, та энийг анхаарах ёстой шүү. Байгууллага удирдаж байгаагийн хувьд. Одбаяр сайдыг би хурал дээр ер нь харсангүй дээ өнгөрсөн хугацаанд. 1 удаа асуудал танилцуулаад явж байгааг нь харсангүй. Уг нь энэ чинь хуультай, харьяа салбартай, бас чамгүй гайгүй орон тоотой, төсөвтэй. Би өнөөдөр энд ирчихсэн байгаа хүмүүсийг буруутгаж байгаа юм биш шүү, зөв ойлгоорой. Хариуцсан, хариуцсан ажилдаа эзэн байцгаая. Парламент нь парламент шиг, Засгийн газар нь Засгийн газар шиг байцгаая. Тэгж байж ажил урагшилна. Үгүй бол энэ хэдэн Улсын Их Хурлын гишүүдийн өмнө очоод аргалсан болоод гараад ирье гэж бодож байгаа бол энэ 126 гишүүнтэй парламентад тийм зарчим байхгүй шүү. Дараа дараагийнхаа ажилд ер нь анхаарах ёстой.

Гантөмөр сайд орж ирж байгаа юм уу. Өнөрбаяр дарга танилцуулж байх уу. Өнөрбаяр даргын микрофон 5 номер.

Ч.Өнөрбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улсын Хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгийн 2024 оны жилийн эцсийн танилцуулгыг та бүхэнд танилцуулъя.

1 дүгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх эрх зүйн үндэслэл бол манай Засгийн газар дахь Хяналтын тухай хуулийн 17.1.4 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны бодлого ажиллагаанд хяналт шинжилгээ хийх нийтлэг журмын 8.5-д заасан заалтын дагуу хийгддэг. Ер нь бол өнгөрсөн хугацаанд бидний хийсэн гол юмыг харахаар Монгол Улсын нийт 89 хуулийн 481 заалт, Улсын Их Хурлын 104 тогтоолын 624 заалт, Улсын Их Хурлын Байнгын хорооны 79 тогтоолын 455 заалт, нийт 272 шийдвэрийн 1550 заалт үнэлгээний мэдээллийн нэгдсэн системд бол бүртгэлтэй байна.

Энэ системд бүртгэлтэй хууль тогтоомжийн актуудад үнэлгээ хийснээр нь ярих юм бол Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн санд бүртгэлтэй Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийн үнэлгээний ангиллаар нь авч үзэхэд 569 буюу 36,7 хувь нь бол бүрэн хэрэгжсэн, 390 буюу 25,2 хувь нь хэрэгжилтийнхээ шатад байгаа, 224 буюу 14,5 хувь нь хэрэгжилт нь хангалтгүй, 196 буюу 12,6 хувь нь хэрэгжээгүй гэж дүгнэчихсэн байна. Харин хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй гэсэн үндэслэлээр 170 заалт үнэлэх боломжгүй байсан. Хэрэгжилт бол дунджаар л 66,4 хувьтай байна гэж гарсан.

Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй байгаа хуулийн нийт 481 заалтын 69 буюу 14,3 хувь нь хэрэгжээгүй, Улсын Их Хурлын тогтоолын нийт 624 заалтын 80 хувь буюу 12,8 хувь нь хэрэгжээгүй, Улсын Их Хурлын Байнгын хорооны нийт 445 заалтын 44 буюу 9,9 хувь нь хэрэгжээгүй бөгөөд Хууль, Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын нийт 1550 заалтын 193 буюу 12,5 хувь нь хэрэгжээ байна.

Яг энэ дотроосоо Ёс зүй, дэгийн байнгын хорооны тогтоолтой холбоотой гаргая. Тэгээд 2024 онд бол нийт 4 заалт, тэгээд дундаж хэрэгжилт нь бол 53,8 хувьтай байгаа. 2023 онд бол Ёс зүй, дэгийн байнгын хороо Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо гэсэн нэртэй байсан. Үүнээс бол Ёс зүй, дэгийн байнгын хороо нийт 2 тогтоолын 14 заалт бүртгэлтэй байгаа бөгөөд 2023 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилт 53,8 хувь, 2024 оны 6 дугаар тогтоолын хэрэгжилт 68,5 хувьтай байна.

Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, шийдвэрийн хэрэгжилтээс энэ дотор ялангуяа Ёс зүй, дэгийн байнгын хороотой холбоотой 2 тогтоолыг онцолж яривал энэ дээр би та бүхэнд урьдчилсан байдлаар Баярбаатар дарга болоод Байнгын хорооны гишүүдэд мэдээллийг бид нар бас дэлгэрэнгүй танилцуулга хүргүүлчихсэн байгаа учраас та бүхэн бас танилцсан байх.

Ер нь бол Ёс зүй, дэгийн байнгын хороотой холбоотой 2 тогтоол, шийдвэр байгаагаас 1 нь бол бүрэн хэрэгжсэн. 1 нь бол хэрэгжилт нь хангалтгүй гэсэн ийм үнэлгээтэй байна.

Цаашаа яваад Засаг даргын Тамгын газартай холбоотой бусад юмыг бол дэлгэрэнгүй хүргүүлчихье.

Нийт Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолтой холбоотой заалтуудын хэрэгжилтийг бол мөн дэлгэрэнгүй гаргасан байгаа. Энэ дээр ялангуяа Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн ёс зүйн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох төслийг

боловсруулан Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан өргөн мэдүүлэх гэж заалт байсан. Энийг бол тайлагнасан байгууллага нь бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газар. Тэгээд дундаж үнэлгээ нь бол 30 хувьтай гарсан байна.

Мөн Засгийн газрын хуульд заасан бүрэн эрх хэрэгжүүлэн шийдвэр гаргахдаа төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжид заасан зарчим, нийтлэг хэм хэмжээ шаардлагад нийцүүлж байх гээд. Энийг нийтдээ 16 яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын Газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хяналт хэрэгжүүлэх газар хариуцаж байсан. Тэгээд энэ бол нийт биелэлт нь бол 88,5 хувьтай байж байгаа.

Төрийн өндөр албан тушаалтан хууль тогтоомжид заасан ёс зүйн зөрчил гаргавал өөрийн хүсэлтээр албанаасаа чөлөөлөгдөх, холбогдох байгууллагаар шалгуулдаг байх соёлыг хэвшүүлэхэд Засгийн газрын манлайлал, үүрэг оролцоог дээшлүүлэх гэсэн заалтын хэрэгжилтийг нийт 19 яам, дээрээс нь Боомтын сэргэлтийн Үндэсний хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцаж байгаа. Энэ бол 98 хувьтай байж байна.

Иргэн, төрийн байгууллага, төрийн албанд анх ороход тавих ёс зүйн шаардлагыг өндөрсгөх, ёс зүйн зөрчил гаргаж байсан хүнийг төрийн жинхэнэ албанд томилохгүй, албан тушаалд дэвшүүлэхгүй байх зарчмыг хатуу мөрдөх гээд нийтдээ бол 50 байгууллага хариуцаж байгаа. Үүнээс хэрэгжилт нь бол 98,2 хувьтай.

1.5 буюу Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог байгуулах. Уг дэд хорооны ажлыг мэргэжил, арга зүйн зохион байгуулалт, удирдлагаар хангах үйл ажиллагааг жигдрүүлэх гэдэг заалтын хэрэгжилтийг бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцаж байгаа. Энэ бол 100 хувийн биелэлттэй байж байгаа.

Нийгэмд ёс суртахууны эерэг чиг хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр ерөнхий боловсролын болон их дээд сургууль, шинжлэх ухаан, соёл урлаг, хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн бус байгууллагууд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах гэдэг дээр бол Цахим хөгжлийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Соёл, спорт, аялал жуулчлалын яам хариуцаж байгаа. Биелэлт нь бол 100 хувьтай байж байна. Цахим орчинд ёс суртахууны үнэт зүйлсийг эрхэмлэх хүрээнд нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх, ёс зүйгүй харилцаа, хандлагыг өөрчлөх, олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, хуулийн этгээдтэй хамтран ажиллах эрх зүйн орчныг бий болгох гээд энэ дээр бол Цахим хөгжил, харилцаа холбооны яам хариуцаж байгаа. Тэгээд үнэлгээ бол байхгүй. Хэрэгжилтгүй байгаа гэсэн үг.

Нийгмийн ёс, суртахууны түвшин, чиг хандлагын талаар мэргэжлийн байгууллага эрдэмтдээр суурь судалгаа хийлгэж, түүний үр дүн, санал зөвлөмжийг төрийн бодлого боловсруулахад тусгах гээд энэ Соёл, спорт, аялал жуулчлалын яам тайлагнасан. Тэгээд энэ бас тайлагналт байхгүй. Хангалтгүй байж байгаа. Хэрэгжээгүй гэсэн үг.

Шинжлэх ухааны судалгаа ололтод тулгуурлан ёс зүйн боловсролыг төлөвшүүлэх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт иргэний ёс зүй, ёс зүйн үндэс, их дээд сургуульд мэргэжлийн ёс зүй хичээлийг заавал судлах сэдэв болгон

сургалтын агуулга, заах арга зүйг шинэчлэн сайжруулах, багш нарыг мэргэшүүлэх, хэвлэмэл болон дижитал сурах бичиг, сургалтын хэрэгслээр хангах ажлыг цогцоор нь шийдэж ёс зүйн боловсролын чанарыг шинэ шатад гаргах гээд энийг бол Боловсролын яам хариуцаж тайлагнасан. Тэгээд хэрэгжилт нь 70 хувьтай байж байгаа.

Тогтоолын биелэлтийн явцыг Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Ерөнхий сайд, мөн Боловсрол, шинжлэх ухааны сайд, Төрийн албаны зөвлөлийн дарга нарт даалгасан байсан. Үүний хэрэгжилтийг бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцаж байгаа. Биелэлт нь 100 хувьтай.

Байнгын хорооны 2023 оны 10 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1.3, 1.6, 1.7, 1.8, 1.9 дэх дэд заалтад заасан арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, нийгмийн болон Монгол хүний ёс суртахууны түвшинд чиг хандлагыг тодорхойлох, суурь судалгаа хийж судалгаанд суурилсан бодлого боловсруулах гээд энийг бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжлийн яам, Боловсролын яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яам хариуцаж байгаа. Нийт дундаж үнэлгээ нь бол 44 хувьтай гарсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр гээд 2024-2030 оны хооронд хэрэгжих, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж жил бүр тайлагнах гэсэн байгаа. Тэгээд энэ заалтын хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Үндсэн хуульд заасан бусад байгууллагууд, нийт яам, Засгийн газрын агентлагууд, аймаг, нийслэл, 21 аймаг тайлагнасан. Хэрэгжилт нь бол 34,4 хувьтай байж байгаа.

Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж үр дүнг тайлагнаж ажиллах гээд. Энийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, тэгээд Үндсэн хуульд заасан бусад байгууллагууд, нийт яам, Засгийн газрын яам, агентлаг, 21 аймаг тайлагнасан. Хэрэгжилт нь 83,2 хувьтай байж байгаа.

Тогтоолын хэрэгжилтийн явцыг Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын ёс зүйн хороонд даалгасан байсан. Үүний хэрэгжилтийн хугацаа нь болоогүй байгаа. Ер нь бол Засгийн газрын Хэрэг эрхлэх тайлагнаж байгаа гэсэн байгаа.

Эндээс товчхон дүгнэлт хийхэд бол төрийн захиргааны төв байгууллагууд бол хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа харьяа байгууллагын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэн тайлагнахгүй байна. Зөвхөн яамны хэмжээнд хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлагнаж байгаа нь хэрэгжилт бүрэн дүүрэн тодорхой гарахгүй байх 1 үндэслэл болж байна.

2-т бол Улсын Их Хурлын тогтоол болон Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг чиглэл болгосон шийдвэр гарсан тухай бүр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт бол хүргүүлэхгүй байгаагаас зарим

шийдвэрийг тухай бүр цахим мэдээллийн санд хяналтад авч бүртгэх боломжгүй байгаад байгаа. Үүнээс болоод бас хэрэгжилтийг нь бид нар бас үнэлж дүгнэж чадахгүй байгаад байгаа ийм тохиолдлууд байгаа.

3-д нь бол холбогдох байгууллагууд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа өмнөх тайлант хугацааны биелэлттэй харьцуулан үзэж, хүрсэн үр дүнг тайлагнаагүй, утга агуулгын хувьд алдаатай тайлагнах, өмнөх оны хэрэгжилтийг хуулбарлан давтаж тайлагнах, өөрийн үнэлгээг бодитой үнэлээгүй зэрэг бас нийтлэг алдаанууд байгаад байна. Тэгээд цаашдаа бол холбогдох хууль, тогтоомжоор үүрэг чиглэл өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг богино хугацаанд бол бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажилла, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр бас Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо энэ чиглэл дээр бас зөвлөмж, чиглэл өгвөл бас илүү сайн байна гэж хэлэх гэсэн юм.

Мөн Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг чиглэл болгосон шийдвэр гарсан тухай бүр шийдвэрийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж байж асуудлыг бас холбогдох байгууллага руу уламжлан шийдвэрлүүлмээр байна. Тэгэхгүй бол манай дээр жишээлбэл Улсын Их Хурлын гаргасан тогтоол, Байнгын хорооны тогтоол бол хугацаандаа ирдэггүй. Жишээлбэл 2024 оны 1 сард ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Өнөрбаяр даргын микрофоныг нэмээд өгчих. Дуусах гэж байна.

Ч.Өнөрбаяр: Улсын Их Хурлын 2024 оны 1 сард батлагдсан байсан тогтоол 12 сард жишээлбэл манайд ирүүлээд, системд бүртгэгдсэн. Гэтэл бид нар 12 сарын 19-нд ирсэн тогтоолын чинь хэрэгжилтийг 12 сарын 25-ны дотор гарна гэхээр энэ маш боломжгүй. Иймэрхүү хүндрэлтэй байдлууд байсан.

Тэгэхээр цаашдаа бас холбогдох байгууллагууд маань бас энэ Их Хурлын болоод Байнгын хороодын тогтоол шийдвэрийг цаг тухайд нь алдахгүй манайд ирүүлж байвал бид нар хэрэгжилтийг нь бол тухай бүр нь үнэлээд явах боломжтой байгаа гэдгийг хэлье.

Тэгээд дээрээс нь Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн чиг үүрэгт хамааралгүй болсон шийдвэр хүчингүй болсон, дахин шийдвэр гарсан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон зэрэг нийт 519 заалтыг Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн сангаас хасах саналтай байгаа юм. Яагаад гэхээр энэ бол үнэхээр ач холбогдолгүй, үнэлэх боломжгүй байгаа учраас хасахгүй бол бид нар заавал тэрийг үнэлэх ёстой болчихоод байдаг. Систем дээр нь харагдаад байдаг. Гэтэл тэр нь өөрөө үнэндээ бол зарим нэг нь хэрэгжээд дуусчихсан, зарим нь хүчингүй болчихсон, зарим нь бол цаг хугацаа, ач холбогдлын хувьд болчихсон ийм зүйлүүд байгаа юм. Баярлалаа.

Б.Баярбаатар: Өнөрбаяр даргад баярлалаа. Яг Ёс зүй, дэгийн байнгын хороотой холбоотой чиглэлээр мэдээллийг хүргэлээ. Ер нь бол аль аль талдаа бас ойлгох нь зөв. Нэг талаасаа Ёс зүйн хороо анхлагч байгууллага. Хууль нь батлагдаад бас төдийлөн удаагүй байгаа, хэрэгжиж эхэлж байгаа. Тэгээд өнөөдөр Төрийн албаны зөвлөлөөс санаачлаад зохион байгуулж байгаа төрийн албан

хаагчийн бүсийн зөвлөгөөнүүдийг хийгээд явж байгаа. Одоогоор бид нар 4 бүсэд хийгээд дуусчихсан байна. Ирэх 7 хоногт баруун бүс, тэрний дараагийн 7 хоногт хангайн бүс гээд тэгээд нийслэл рүүгээ орж ирнэ. Тэгээд энэ ажлын үр дүн бол жишээлбэл дараа нь дүгнэгдэхдээ бол их өндөр хувьтай гарах болов уу гэж би хүлээлттэй байгаа. Хууль, эрх зүйн орчны сурталчилгаа, дээрээс нь хэрэглээ, хуулийн хэрэглээ, дэд хороодоо чадавхжуулах, соён гэгээрүүлэх хөтөлбөрүүд эд нар гээд нэлээн өргөн хүрээний 2 өдрийн ийм зүйлүүдийг хийгээд явж байгаа. Нэг талаасаа.

Нөгөө талаасаа Өнөрбаяр даргын ахалж байгаа энэ байгууллага бас байгуулагдаад удаагүй. Шинэ байгуулагдсан салбар явж байгаа. Өргөн хүрээний хяналтын ажлыг хийх ёстой. Хийж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд дараа дараадаа Их Хурлын хяналт шалгалтын газар, энэ хяналт шалгалтын яам нарын үнэлгээ хийдэг энэ зүйлүүд дээрээ нэгдэхгүй бол бид нар чинь тэгээд зөрүүтэй зөрүүтэй тоонууд оруулж ирээд, тэгээд тэр дээрээ өөрсдөө буцааж байцаагдаад, тэр дээрээ буруу зөрүү ойлголтууд өгөөд, тэр дээрээ асуудал нь ингээд сулраад унаад байгаа юм шиг ийм нөхцөл байдал бол бас ажиглаад байгаа шүү. Энийгээ бид нар анхаарах, сая Өнөрбаяр дарга үгийнхээ төгсгөлд хэлж байгаа тэр санаануудыг бол тусгаж аваад ажил болгоод явах нь бас зүйтэй гэж бодож байна.

Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Аюушийн Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Энэ үнэлгээтэй холбоотой бас хэт субъектив байдлаар үнэлсэн үнэлгээнүүд харагдаад байгаа юм. Тэгээд Өнөрбаяр дарга ч гэсэн өөрөө хэлж байна. Ер нь өгч байгаа үүрэг даалгаврыг биелэгдэх боломжтой, тайлант хугацаанд хэрэгжүүлэх боломжтой байдлаар үүрэг даалгавар нь анхнаасаа тэгж зөв өгөгдөхгүй бол дараа нь үнэлгээ дээр ч гэсэн их асуудал гарах юм байна. Энэ үнэлгээний 4 дүгээр хуудсан дээр байгаа 3 дугаар зүйл дээр нь заасан Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороог байгуулах ажлыг мэргэжил, арга зүйн зохион байгуулалтын удирдлагаар хангаж, үйл ажиллагааг жигдрүүлэх гэсэн заалтын үнэлгээг 70 хувиар үнэлсэн. Одоо бууруулан үнэлсэн гэж байгаа юм. Тэгээд яагаад бууруулчхав гэсэн чинь үнэлгээг бууруулсан шалтгаан нь эрх зүйн орчин сайжирсан. Нийт 2281 ёс зүйн дэд хороо байгуулсан. Гэсэн ч 2018-2023 онд буюу өмнөх 5 жилийн дунджаар жилд 495 албан хаагч ёс зүйн зөрчил гаргаж байсан гэж дүгнэж байсан бол 2024 онд 595 болж өссөн үзүүлэлттэй байгаа учраас үнэлгээг нь 70 хувь болгож бууруулсан гэнэ. Үгүй ээ, харин эсрэгээрээ илүү олон хүн гомдол гаргаж байгаа юм бол үнэлгээ нь илүү сайжрах ёстой юм биш үү. Гомдол гаргахгүй байх нь Ёс зүйн дэд хорооны хийж байгаа ажил нь сайн байна гэсэн үг биш биз дээ.

Тэгээд өнөөдөр ч гэсэн 1 гишүүн чуулганы танхимд гомдлоо л гээд байна. Ёс зүй, дэгийн байнгын хороонд хандаж, хуулийнхаа процессынхоо дагуу үйл ажиллагаагаа явуулах ёстой биз дээ. Гэтэл тэгээд л бүр төрийн хямрал болтол нь ингэж дөвийлгөөд, Ёс зүй, дэгийн байнгын хороо юуны тулд байгаа юм. Ёс зүйн хороонууд юуны төлөө байгаа юм. Гомдлуудаа гаргахын төлөө л байгаа биз дээ. Тэгээд хуулийнхаа дагуу тухайн зохицуулалтуудаа хийгээд, шийдвэрүүдээ гаргаад явах ёстой.

Ер нь бол өнөөдөр энэ парламентын болоод энэ засаглалын хямрал бол ердөөсөө л бид нар хуулиа уншдаггүй, хуулиа хэрэгжүүлдэггүй, хуулийнхаа хүрээнд үйл ажиллагаагаа явуулахгүй байгаад оршиж байна.

Нөгөө талд нь болохлоор цахим орчинд ёс суртахууны үнэт зүйлийг эрхэмлэх хүрээнд нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх, ёс зүйгүй харилцаа хандлагыг өөрчлөх, олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, хуулийн этгээдтэй хамтран ажиллах эрх зүйн орчныг бий болгох гэсэн ийм үүрэг даалгаврыг өгсөн байна. Өнөөдөр эргээд л нөгөө 1 гишүүн рүүгээ хандахад үгүй ээ, энэ нийгмийн сүлжээ дээр чинь аймшигтай юм болж байна шүү дээ. Гэр бүл рүү нь, хүүхэд рүү нь дайрсан асуудлууд байна. Гэхдээ энэ 2 холбогдогч этгээдийн асуудал огтоос биш. Хэн ийм мэдээлэл гаргаж байгаа нь тодорхойгүй, хэн коммент бичиж байгаа нь тодорхойгүй. Ингээд нийгмээрээ ийм хуурамч сүлжээ дээр суурилад, нэгнийгээ харлуулах, гүтгэх, доромжлох бүр хэрээс хэтэрч байна шүү дээ. Зөвхөн энэ гишүүнтэй холбоотой ч биш, сонгуулийн үеэр нэн ялангуяа энэ асуудал нэмэгддэг.

Тэгээд эргээд харахад нөгөө сэтгүүлчид өөрсдөө хүртэл хувийн аккаунтаараа бичдэг. Тэгээд энэ өөрөө хэвлэлийн эрх чөлөө мөн юм уу. Нийгмийн сүлжээг бид нар зохицуулахгүй хэвээрээ байх юм уу. Энэ асуудал манай энэ чиглэлд орсон байна шүү дээ. Яаж өөрчлөх вэ.

Б.Баярбаатар: Хэн хариулах вэ. Өнөрбаяр дарга хариулъя. 5 номер.

Ч.Өнөрбаяр: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. 1.4-ийг бол манай яг үнэлгээг бол түрүүний ёс зүйтэй холбоотой асуудлыг 70 гэж үнэлээгүй. 98,2 хувьдаа үнэлсэн байгаа. 100 гэж үнэлсэн байгаа. 1.5-ыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцдаг. Тэгээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр бол нөгөө Солонгоо даргаар ахлуулаад, Ёс зүйн дэд хороо байгуулагдаад ажиллаад явж байгаа. Тэгээд ер нь энэ дээр Их Хурал дүн шинжилгээ хийхдээ Их Хурлын Тамгын газраас 70 гэсэн. Тэгэхдээ тэр үндэслэлийг манай Их Хурлын Тамгын газрынхан бас тайлбарлачих байх.

Тэр 2 дахь асуудалтай бол тантай санал нэг байна. Энэ цахим орчинд ер нь энэ ёс суртахууны үнэт зүйлсийг дээрэмдэх, нэгнээ хүндэтгэлтэй хандах энэ тэр гээд энэ юмнууд бол үнэхээр болохгүй байдалд орсон. Энэ дээр бол бас Засгийн газарт ч Байнгын хороо чиглэл өгч байсан. Харамсалтай нь бол энийг Цахим хөгжил харилцаа холбооны яам тайлагнадаг. Тэгээд одоогоор хэрэгжилт нь бол байхгүй байж байгаа. Энэ тал дээр бол би бол зөвхөн цахим яамны ч ажил биш Хууль зүй, дотоод хэргийн яам. Энэ бол явж явж хүний эрхийн зөрчлийн асуудал. Тэгээд мэдээж хэрэг олон асуудлууд байгаа учраас энийг бол ер нь цогцоор нь шийдэх ёстой гэсэн ийм зүгээр хувийн байр суурь. Тэгэхдээ яг энэ манай чиг үүрэгт гишүүн ээ ордоггүй учраас манайх бол аль болохоор бодитой л дүгнэсэн. Үүний үнэхээр хэрэгжилт нь бол энэ бол хангалтгүй байгаа зүйл мөн. Энэ дээр бол ахиц дэвшил гарах ёстой гэж хэлж байна. Баярлалаа.

Б.Баярбаатар: Их Хурлын Тамгын газраас хариулах уу. Микрофон дээр сууж байгаад 4 номер дээр очоод суучих. 4 номер. Өөрийгөө танилцуулаарай.

Б.Алтантуяа: Гишүүний асуултад асууя. Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Алтантуяа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар 4 дүгээр сарын 2-ны өдөр бол Ёс зүйн хорооны тайланд ажиглалт компаниас хийсэн дүн шинжилгээний тайланг хүргүүлсэн. Энэ дээр бол бас хууль тогтоомжийн хэрэгжилт хэдэн хувьтай байгааг бол дэлгэрэнгүйгээр хүргэсэн байгаа. Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлт бол бас Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын ирүүлсэн тайланд бол Үнэлгээ, мониторингийн газраас дүн шинжилгээ хийж байгаа. Энд бол Ёс зүй, дэгийн байнгын хорооны харьяалах асуудлын 1.5 дээр Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог байгуулах, дэд хорооны ажлыг мэргэжил, арга зүй зохион байгуулалтын удирдлагаар ханган үйл ажиллагааг жигдрүүлэх гэдэг бол тодорхой хэмжээгээр хэрэгжсэн. 100 хувтай гэж Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн. Манай үнэлгээчид бол Ёс зүйн хорооны 13 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, өргөдөл гомдол нэмэгдсэн байдал болон улсын хэмжээнд 2281 ёс зүйн дэд хороо байгаа. Дэд хорооноос 1659 нь бол цахим системийг нэвтрүүлсэн байна гэдгийг бол яг 100 хувийн хэрэгжилттэй гэж үзэхгүй байгаа юм. Тодорхой хэмжээгээр энэ ёс зүйн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой Ёс зүйн дэд хороонууд байгуулагдаад, үйл ажиллагаагаа явуулж байгаа нь хангалттай байгаа боловч энийг цахимжуулах систем болон өргөдөл гомдол нэмэгдэж байгаа нь өөрөө Ёс зүйн хороо сайн ажиллах, хуулийн хэрэгжилтийг улам сайжруулах, Их Хурлын тогтоол болон Байнгын хорооноос гаргаж байгаа тогтоолын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай гэдгээр үнэлгээг бол 70 хувь буюу тодорхой хэмжээнд үр дүнд хүрсэн гэж үнэлсэн байна. 100 хувь бол яг бүрэн хэрэгжчихсэн, бүх Их Хурлын тогтоол, бүх Байнгын хорооны тогтоол яг энэ 1.5 100 хувь хэрэгжиж байгаа гэдэг дээр бол ийм үнэлгээ өгөх ёстой байгаа юм. Ингээд энийг бол бас батлах дүн шинжилгээ хийсэн байгаа. Батлах дүн шинжилгээ хийсэн 2 албан хаагч бол бас 70 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Б.Баярбаатар: Ариунзаяа гишүүн тодруулна.

А.Ариунзаяа: Цагаан дээр хараар бичсэн Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороог байгуулах ажлыг мэргэжил, арга зүйд зохион байгуулалтын удирдлагаар хангана. Үйл ажиллагааг жигдрүүлнэ гэсэн заалт байхад түүн дээр үнэлгээ нь бол бас буруугаар буюу жилд гардаг нь дунджаар 495 байсан бол 595 болж өссөн учраас үнэлгээг буурууллаа гэж дүгнэсэн байгаа чинь өөрөө буруу юм шүү. Сая таны хэлж байгаа тайлбар чинь өөрөө буруу байна гэдгийг хэлье. Ер нь Ёс зүй, дэгийн байнгын хороонд гомдол гаргаж байгаа тоо нь эсрэг гэргээрээ олшрох юм бол буруутай тэмцэх, дуугүй байх хүмүүс нь багасаж байна гэсэн үг. Нөгөө талдаа бол мэдээж хүмүүс энэ жишээ дээрээ суурилад, би өөрийгөө зөв авч явах ёстой юм байна гэдэг хуулийгаа эргэн харах юм. Ийм учраас энэ дээр ч гэсэн бас онцолж үг хэлье гэж бодсон.

2 дахь нь болохоор олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах чиглэлээр бол манай Байнгын хороо Засгийн газарт өгсөн чиглэл байгаа юм бол түүнийгээ сайжруулаад, яг энэ тухайн хаягийн ард хэн байгаа юм. Хариуцлага тооцох юм уу, үгүй юм уу .../минут дуусав/

Б.Баярбаатар: Хэн хариулах вэ. Өнөрбаяр дарга.

Ч.Өнөрбаяр: Ер нь бол энэ чиглэлд Ариунзаяа гишүүний хэлээд байгаа үнэн л дээ. Энэ цахим орчинд хүний эрхийг хамгаалах, хүмүүсийн нэр төртэй холбоотой, ёс зүйтэй асуудлыг цогцоор нь Эрүүгийн хууль, Эрүүгийн процессын хууль, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр ажлын хэсэг байгуулаад Төрийн албаны хуулийн шинэчлэл дээр ч гэсэн энийг нь уяж ойлгохгүй бол зөвхөн ингээд энэ тогтоол гаргаад бас хэрэгжилт нь хангалтгүй байгаа харагдаад байгаа. Тэгээд би цаашдаа бол бас Улсын Их Хурлын гишүүд маань ийм хүсэл зоригтой байдаг байсан. Тэгээд би бол Байнгын хорооноос болж өгвөл Баярбаатар дарга аа, Ариунзаяа гишүүний саяын энэ саналыг илүү эрчимжүүлэх чиглэлээр санал өгчихвөл бид нар бас хэрэгжилт дээр нь бол тогтоол албажаад ирэхээр бол ажиллана. Ер нь хэдүүлээ хаана хаанаасаа шахаад, энэ асуудлыг бол 1 талдаа гаргахгүй бол болохгүй гэсэн ийм байр суурьтай байна. Энэ бол энэ үнэхээр чухал санал. Үнэхээр хэрэгжилт нь ч гэсэндээ үнэхээр 0 байгаа. Одоо энэ дээр нэг их нуугаад хаагаад, зөвтгөөд байх юм байхгүй байгаа.

Б.Баярбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Миний хэлээд байгаа зүйл чинь яг л энэ л дээ. Түрүүн хэлж дуусаагүй байтал ингээд Ариунзаяа гишүүн асуулт асуугаад ороод ирж байгаа байхгүй юу. Засгийн газраас үнэлсэн үнэлгээнийх нь байдал нь болохоор энэ механик үнэлгээ хийчихсэн. Хэдэн дэд хороод байгуулагдав гээд ийм байдлаар хийчихсэн. Гэтэл Их Хурлын Тамгын газраас хийсэн үнэлгээ нь болохоор үр дүнгийн үнэлгээ хийчихсэн байгаа байхгүй юу. Яг ингээд үйл ажиллагаа нь жигдэрсэн үү, гомдол маргаан ингэж яасан байна, хуулиа хэрэгжүүлсэн байдал гээд. Тэгээд энэ 2 нь ингээд зөрөхөөрөө хувь нь мэдээж өөр гарч байгаа шүү дээ. Хувь нь мэдээж өөр. Одоо би бол жишээлбэл Их Хурлын Тамгын газрын Хяналт шинжилгээний газрын хийсэн үнэлгээг зөв үнэлгээ байна гэж харж байна. 70 хувьтай гэдэг үнэлгээг.

Гэтэл яагаад Хэрэг эрхлэх нь өнөөдөр яг хянахдаа 98 хувьтай гээд гаргаад ирэв. Яаж ч бодсон 98 хувьтай хэрэгжилт нь энд харагдахгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ хууль, эрх зүйн орчиндоо байдаг юм уу, ямар түвшинд байдаг юм Өнөрбаяр дарга аа, цэгцлэх зайлшгүй шаардлага байгаа.

2-т саяын Ариунзаяа гишүүний яриад байгаа зүйл үнэн л дээ. Одоо бид нар энэ цахим орчны ёс суртахууны асуудал бол үнэхээр зөвхөн цахим орчных биш. Энэ чинь бүр яг нийгмийн хэмжээний ийм асуудал болж хувирлаа. Одоо энэ дээр бид нар арга хэмжээ авч чадахгүй бол цаашдаа бид нар эндээ дийлдээд унана шүү. Хаа сайгүй.

2-т бас хэрэгжээгүй дараагийн заалт нь нийгмийн ёс суртахууны түвшинд чиг хандлагын талаар мэргэжлийн байгууллага, эрдэмтдээр суурь судалгаа хийлгэж, түүний үр дүн, санал зөвлөмжийг төрийн бодлого боловсруулахад тусгах гээд жишээлбэл энэ дээр манай Рэгдэл гишүүн бол ШУА-ийн Ерөнхийлөгч байсан хүн нэг юм хэлэх байх. Энэ бол хийчхэж болох ажил шүү дээ. Маш өргөн түвшинд ямар ч түвшинд хийгээд бид нар судалгааг нь гаргаж ирээд, энэ дээрээ магадгүй энэ 2-ын чинь байр нь солигдчихсон байхыг үгүйсгэхгүй шүү дээ. Эхлээд бид нар 1.8-аа хийж, судалгаагаа хийчхээд, дараа нь энэ дээр бид нар ийм ийм эрх зүйн орчныг сайжруулах, ийм хуулийн төслүүдийг боловсруулах сайжруулах зайлшгүй шаардлага байгаа юм байна гэдэг төлөвлөгөөгөө гаргаад ажиллах ёстой. Одоо жишээлбэл энэ саяын эхний цахим орчинд ёс суртахууны үнэт зүйлсийг эрхэмлэх

гэдэг энэ хэрэгжээгүй заалт Баатархүү сайдын яам чинь юу билээ. Цахим яам тийм ээ. Цахим хөгжлийн яам. Энэ яам ямар ч мэдлэг байхгүй шүү дээ. Ямар ч ёс зүй мэдэхгүй шүү дээ эд нар. Тэгээд хууль санаачил гээд үүрэг өгчихдөг. Эд нар чинь энэ компьютер дээр код бичээд, программ зохиож мэднэ үү гэхээс биш тийм ёс зүйн талаар асуудал боловсруулах чинь өөрөө ингээд чиглэл нь буруу болчхож байгаа байхгүй юу. Цахим гэдэг үг ороод ирэхээрээ л тэр яаманд хамаатай юм шиг болоод явчхаж байгаа байхгүй юу. Үгүй л дээ. Энэ чинь эсрэгээрээ бараг шал өөр асуудал байхгүй юу. Өргөн хүрээний асуудал. Тэгэхээр энэ чиглэлээсээ эхлээд бид нар зөв хандлагаа тогтоож явахгүй бол дараа нь ингээд 0 хувийн хэрэгжилттэй гэж орж ирээд, 1 нь уурласан, 1 нь асуусан, 1 нь хариулсан ийм л нөхцөл байдалтай ингээд яваад байгаа юм. Тэгээд цаашдаа энийг бид нар бас анхаараад, Байнгын хорооноос тогтоол боловсруулж баталж хүргүүлье. Аль болох бид нар энэ зөв чиглэлээ тогтоогоод, зөв замаараа явах юм бол энэ ажлууд чинь ажил болоход илүү хялбар байна гэж л харагдаад байгаа юм.

Асуулт дууссан. Одоо үг хэлэх гишүүд байвал нэр өгье. Аюушийн Ариунзаяа гишүүн, Рэгдэл гишүүн дараад байна уу, үгүй юу. Дүгэрийн Рэгдэл гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Парламентын төгөлдөршлийг бид нар маш олон түвшинд авч үзэж байгаа энэ цаг үед парламентын гишүүд маань өөрсдөө ёс зүйтэй, хуулиа хэрэгжүүлдэг, мэдлэг мэдээлэлтэй, бусдад үлгэр дуурайлал болохуйц байх ёстой гэдгийг бас үгэндээ хэлье. Энэ бол зөвхөн саяын яригдаж байгаа 1, 2 гишүүнтэй холбоотой ч биш. Ер нь нийтлэг.

Улсын Их Хурлын тухай хуулиар хүлээж байгаа үүрэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 44.1.11 дээр байгаа. Бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ чуулганы хуралдаан, Байнгын хорооны хуралдаан, ажлын хэсэг, тэдгээрээс гадуур ч бай жирийн амьдралдаа ч бай, сошиал орчиндоо ч бай бусдыг гүтгэх, доромжлох нь бол хориотой. Тэгэхээр аль болох ёс зүйтэй байх нь бол гишүүн бүрийн үүрэг. Энд бол би хэн нэгний цохож хэл гэсэнгүй. Бүгдээрээ л энийг бодох ёстой.

2 дахь нь болохоор яг энэ цахим орчинтой холбоотойгоор нэн ялангуяа НҮБ, олон улсын байгууллагууд юуг онцолдог вэ гэхээр эмэгтэй улс төрчдийн цахим орчны гүтгэлэг доромжлол эрэгтэй улс төрчдийнхөөс хамаагүй өндөр байдаг. Сүүлийн шинэ парламентын 126 гишүүнтэй болоод 32 эмэгтэй гишүүнтэй болоход хамгийн их гүтгэлэгт болоод сошиал цахим доромжлолд өртөж байгаа хүмүүс нь хэн бэ гэхээр дахиад л нөгөө эмэгтэйчүүд. Тэгэхээр энэ дээр гарц гаргалгаа нь өөрөө юу юм бэ гэхээр ердөөсөө л нөгөө нэр хаяг нь тодорхойгүй, нэр зураг нь яг өөрийнхөө нэр хаягаараа байдаггүй, тодорхойгүй хаягуудаас зоригтой гүтгэлэг доромжлолуудыг явуулдаг.

Хүүхдүүдийг цахим орчинд бид нар хамгаалж чадахгүй байгаа учраас хүүхдүүдийн цахим орчны хэрэглээг нь хязгаарлая гэдэг асуудлыг Боловсролын сайд яриад явж байгаа. Энэ бол Наранбаяр сайдын ч олоод гаргаад ирсэн асуудал биш. Энэ бол дэлхий нийтдээ хүүхдүүд ээ цахим дайралтаас хэрхэн яаж хамгаалах вэ гэдэг дээр хамгийн анхдагч хуулийг бол Австрали улс бас батлаад 0-16 насны хүүхдийг цахим орчинд бүр оруулахгүй байх, хэрэвзээ аккаунт үүсгэсэн байх юм бол тухайн платформын эзэмшигчдийг 30 мянган австрали доллароор торгох ийм асуудлыг баталсан. Хууль нь хэрэгжээд эхэлж байгаа. Тэгэхээр бидний хувьд хүүхдүүдээ цахим орчноос шууд хязгаарлах нь эргээд нөгөө тухайн

хүүхдүүдийн маань хөгжих, боловсрох эрхэд халдчих вий гэдэг нөгөө өнцгийг нь бас ярих ёстой. Тэгэхээр энэ цахим орчныг ёс зүйтэй, үнэн зөв байлгахын тулд ядаж л нэр хаяг тодорхойгүй ийм хуурамч аккаунтыг хэрхэн яаж байхгүй болгох вэ. Хэрхэн яаж тухайн мэдээлэл бичиж л байгаа бол тэр нь өөрөө эргээд хариуцлага тооцдог байх тал дээр нь хэрхэн яаж хууль, эрх зүйн орчныг шинэчлэх вэ гэдэг бол хамгийн том сорилт болчихоод байна.

Учрал гишүүний тухайн үед өргөн барьж байсан хууль бол яг л энэ албажуулах, хаягжуулах, өөрийнх нь иргэний дугаараар нь эзэмшүүлэх ийм асуудал байсан. Тэгээд үүнийг бол тухайн үедээ хэвлэлийн эрх чөлөө гэдэг асуудлаар бас нэлээд шүүмжилж байж тэгээд болиулсан. Хэвлэлийн эрх чөлөө хаана эхлэх вэ. Хэвлэлийн эрх чөлөө хаана дуусах вэ. Хүний эрх хаана эхлэх вэ. Бусад хүний эрх хаана эхлэх вэ. Хаана миний үүрэг эхлэх вэ. Юугаар миний эрх хязгаарлагдах вэ гэдэг нь бол үнэхээрийн чухал асуудал. Тэгэхээр үүнд манай Байнгын хороо бас хувь нэмрээ оруулах боломж байгаа л юм бол үүн дээр хүчтэй дуу хоолой болж, түүн дээрээ бас хяналт тавьж, эргээд ёс зүйтэй, цэвэр ийм хөгжлийг эрхэмлэсэн ийм парламент болон нийгмийг бий болгоход одоо зүтгэх ёстой.

Б.Баярбаатар: Баярлалаа. Ариунзаяа гишүүн санал хэллээ. Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг манай Байнгын хороо хэлэлцэхээр болсон шүү. Дийлэнх асуудал нь бол сэтгүүлчийн ёс зүй, хэвлэлийн ёс зүй, ёс суртахууны асуудал байгаа учраас манай Байнгын хороо анхны хэлэлцүүлгийн түвшинд бол хэлэлцүүлэг явуулна. Дүгэрийн Рэгдэл гишүүн санал хэлнэ.

Д.Рэгдэл: Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний танилцуулгатай танилцлаа. Тэгэхээр Монгол Улсын Ёс зүйн хороо байгуулагдаад их удаагүй. Энэ талаар Байнгын хорооны дарга ч бас хэд хэд хэлчихлээ. Гэхдээ үүнээс хойш бол удаагүй гэдэг тодотголоо арилгах ёстой. Арилгахын тулд тодорхой ажлуудыг гарцаагүй хийхээс өөр арга байхгүй гэж бодож байгаа юм.

Тэгэхээр энэ Ёс зүйн хороо, түүний харьяанд байх бүтэц, тогтолцоонд байх дэд хороодын тухай манай Байнгын хорооноос ажлын хэсэг гаргаад, бас тайлан тооцоогоо танилцуулсан зүйл байгаа. Тэнд бол анхаарал татсан асуудал бол энэ Ёс зүйн дэд хороо ямар зохион байгуулалттай байвал зохимжтой юм бэ. Орон нутагт байгаа Ёс зүйн дэд хороог энэ төрийн байгууллагуудаар нь байгуулаад байх юм уу, үгүй юм уу. Их олон жижиг цөөхөн хүн амтай төрийн байгууллагууд сумдад байдаг. Энэ орон нутгийн хэмжээнд нь нэгдсэн зохион байгуулалт хийх боломж байна уу, үгүй юу зэрэг асуудлаар бас санал, дүгнэлтээ гаргачихсан байгаа.

Тэгэхээр Ёс зүйн дэд хороо энэ санал, дүгнэлтээ танилцсан. Мэдэж байгаа. Үүнийхээ дагуу манай Байнгын хороод танилцуулга энэ тэр өгөөгүй юм шиг байна. Ингэж зохион байгуулах нь зөв юм. Энэ нь буруу юм энэ тэр гээд үндсэндээ энэ чинь зарим нэг тоог харахаар 400 гаруй байгууллага байгаад байдаг. Тэгээд 4 мянга гаруй байгууллага улсын хэмжээнд байна. Тэгэхээр 2 мянга орчим нь дэд хороогоо байгуулчихсан, бусад нь байгуулаагүй яваад байдаг. Тэгээд байгуулаагүй мөртөө энэ дэд хороог санхүүжүүлэх, цалинжуулах энэ асуудал л чухал байна гэж ганц юм яриад ингээд яваад байж болохгүй л дээ. Зохион байгуулалтын хувьд тодорхой саналаа бид нарт танилцуулж өгвөл зөв байгаа юм. Яаж байгуулбал зүгээр юм.

Тэгээд, мэдээж энэ ёс зүйн боловсрол гэдэг бол угаасаа том асуудал. Энэ бол цогц асуудал. Аль нэг ганцхан Боловсролын яамны хариуцдаг асуудал ч биш. Ганцхан Ёс зүйн хороо ч бариад гүйцэтгэх асуудал биш. Тэгэхээр энд 2 зүйлийн судалгааны ажлыг Монгол Улсын Ёс зүйн хороо санаачилж хиймээр байгаа юм.

1 дүгээрт энэ ёс зүйн боловсролын дэлхийн туршлагыг судлах хэрэгтэй байгаа юм. Энэ хэцүү биш байх гэж бодож байна.

2 дугаарт Монгол Улсын эрдэм шинжилгээний байгууллагуудаар Монгол улсад ёс зүйн боловсролыг дээшлүүлэхэд тулгамдаад байгаа асуудал шийдлийн талаар судалгаа хийлгэмээр байгаа юм. Бага зэргийн санхүүжилт орох байх. Тэгээд энэ хоёроо харьцуулж байгаад энэ ёс зүйн боловсролынхоо асуудлыг үндсийг нь сайн үндэс тавиад өгчихвөл ганц нэг хөтөлбөрийн тухай ярихаа байгаад, ямар хөтөлбөр шаардагдаж байна вэ, тэрийг яаж хэрэгжүүлэх вэ гэдэг энэ арай том асуудал руугаа шилжиж орох болов уу гэсэн ийм бодол байна.

Энэ танилцуулгын дүгнэлтүүд үндсэндээ ажил хэрэгч дүгнэлт болсон гэж би ойлгож байгаа. Энэ чинь одоо болтол Их Хурал, түүний бүтцийн байгууллагуудын шийдвэр чиглэл өгсөн, ялангуяа Засгийн газарт чиглэл өгсөн тогтоолуудыг энд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хугацаанд нь өгдөггүй одоо хүртэл ингээд явж байдаг бараг 12 сарын дараа гарсан шийдвэрийг танилцуулдаг. Энэ бол ер туйлын хариуцлагагүй л асуудал л даа. Энд буруу нь хаанаа байдаг юм мэдэхгүй байна. Аль газар нь үүнийг нь цагт нь хүргэж өгч байх ёстой юм. Үүнийг ер нь жигдрүүлээд авчих хэрэгтэй. Жигдрүүлээд авчих хэрэгтэй.

2 дугаарт энэ дээр саналтай байгаа. 520-оод заалтыг .../минут дуусав/

Б.Баярбаатар: Рэгдэл гишүүнд 1 минут нэмээд өгчих.

Д.Рэгдэл: Хасъя гэж. Тэгээд энэ дээрээ дахиж Өнөрбаяр дарга 1 сайн анхаараарай. Энэ чинь угаасаа хийгдээгүй юм орж ирээд хасагдаад, биелэлтийг нь үзэх ёстой юмнууд энэ дотор орчих вий. Үнэхээр ач холбогдолгүй болчихсон, хүчингүй болчихсон, ерөнхийдөө Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хамааралгүй болчихсон тийм юмнуудаа гаргаад нэгмөсөн хасчихвал цаашдын ажилд чинь нэмэр болох байх. Ийм л санал байна. Асуулт алга.

Б.Баярбаатар: Рэгдэл гишүүн санал хэллээ. Өнөрбаяр дарга 1 тайлбар хэлчих. Би ч санал хэллээ, 2 гишүүн санал хэллээ.

Ч.Өнөрбаяр: Баярлалаа. Тэгээд Баярбаатар даргын хэлээд байгаа үнэн л дээ. Нөгөө манайх одоо байгаа үнэлдэг журмаараа 2020 оны 206-аар үнэлж байсан. Тэгээд тэр нь яг таны хэлээд байгаа шиг зөвхөн арга хэмжээ үнэлдэг, үр дүнг ерөөсөө үнэлж чаддаггүй. Тэгээд үүнээс болоод Их Хурлын тэр дүн шинжилгээтэй зарим нь зөрөөд байгаа юм ч байгаа. Одоо бол энийг бид нар өөрчлөх ёстой гээд Баярбаатар дарга аа, яг таны хэлж байгаа шиг ер нь үр дүнгээр нь үнэлдэг байя, хэрэгжилтийг нь үнэлдэг байя. Зөвхөн арга хэмжээ үнэлдгээ больё гээд 3 цогц журам Засгийн газрын хурлаар батлуулсан. Тэгээд энэ журмууд маань энэ 5 сарын 1-ээс мөрдөгдөөд явж байгаа. Тэгээд ирэх жил бол энэ 3 журмын дагуу үнэлэх учраас энэ таны яриад байгаа шиг асуудал гарахгүй байх. Үнэхээр үнэн. Энэ 4 жилд бол дандаа бид нар арга хэмжээ үнэлээд, үр дүнг

үнэлэхгүй явж ирсэн юм. Энэ нь бас үнэлж байгаа журамтай холбоотой байсан гэдгийг бас хэлье.

2 дугаарт Рэгдэл гишүүний анхааруулж хэлж байгаад баярлалаа. Тэр хасах заалтуудыг дахиж бид нар нягталъя. Ерөнхийдөө энэ дээр бас үнэхээр ач холбогдолгүй болчихсон бол хасах нь зүйтэй гэж ойлголоо. Тэгээд цаашдаа бол Улсын Их Хурлын Тамгын газар, манай Хяналт хэрэгжүүлэх газар ажлаа уялдуулчих юм бол ирэх жил маш олон юман дээр үр дүн гарах байх. Энэ дээр бол ажлаа уялдуулаад явна гэсэн ийм бодолтой байна.

Тэгээд Баярбаатар даргын хэлээд байгаа тэр үр дүнг үнэлдэг юм руу бол ирэх жил бол бид нар үнэлгээ орчих учраас бол энэ дээр асуудал гарахгүй гэдгийг танд бас хариуцлагатайгаар хэлье.

Ариунзаяа гишүүний хэлээд байгаа ажил хэрэгч саналууд дээр бид нар бас өргөн хүрээнд хамтарч ажиллах ёстой. Үнэхээр зарим юм нь ийм байгаа юм. Баярбаатар дарга аа, Ариунзаяа гишүүн ээ, нөгөө чиглэл өгөхдөө эзнээ олдоггүй. Яг нөгөө хариуцах ёсгүй, чиг үүрэггүй хүмүүст бас маш их үүрэг оноочхоод, тэгээд нөгөөдүүл нь мэдээж хуулийнхаа дагуу хариуцахгүй юм чинь хэрэгжилтийг гаргаж ирж чаддаггүй. Ингээд 0 болоод байгаа юм бас байгаа. Тэгэхээр энэ тал дээр бас бид нар ч анхааръя. Та бүхэн ч бас Их Хурлын гишүүдийн хувьд Байнгын хороо маань бас Улсын Их Хурлаас гадна Засгийн газарт бүхэлд нь хяналт тавих хэрэгтэй учраас энэ хүрээндээ та бүхэн бас чиглэл өгөөд, тодорхой чиглэл өгвөл бас бидний ажилд ч гэсэндээ бас их тийм тустай байна гэдгийг хэлье. Баярлалаа.

Б.Баярбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Улсын Их Хурлын 2023 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 32 дугаар тогтоол, 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 27 дугаар тогтоол болон Ёс зүй, дэгийн Байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 10 тоот, 2024 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн 6 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах зайлшгүй шаардлагууд байгаа.

Тэгээд тогтоолд дурдагдсан байгууллагууд тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг хурлын тэмдэглэлээр үүрэг болгоё.

Ингээд өнөөдрийн 2025 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн Ёс зүй, дэгийн байнгын хороо хэлэлцэх асуудлаа дуусгалаа. Өнөөдрийн хурал хаасныг мэдэгдье.

14.03 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ